



МNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

**УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2023.12.01-
2023.12.28 ХҮРТЭЛ ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН МЭДЭЭ**

Тайлангийн дугаар: Хяналт/2024/01

Хэвлэсэн огноо: 2024.01.24

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын FM радио нэвтрүүлэх станцад MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг хангуулах, технологийн норм, горимыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх зорилготой.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2023.12.01-2023.12.28	<ul style="list-style-type: none"> - СБД-ийн 6-р хорооны ХХЗХ-ны төв оффисын дээвэрт байрлах сууурин хяналтын станц - ХУД-ийн 20-р хорооны ТВ5 телевизийн төв оффисын дээвэрт байрлах сууурин хяналтын станц - СХД-ийн 34-р хорооны ХХЗХ-ны РДӨНХТ-ийн цамхагт байрлах сууурин хяналтын станц 	47°55'39.21"N 106°54'53.20"E 47°53'47.63"N 106°53'13.10"E 47°54'51.50"N 106°45'43.33"E



Зураг 1а. Хэмжилт хийсэн FMS-2014 суурин хяналтын станцын байршил.



Зураг 1б. Хэмжилт хийсэн TMDFS суурин хяналтын станцын байршил.



Зураг 1в. Хэмжилт хийсэн FMS-2020 суурин хяналтын станцын байршил.

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

FMS-2014 суурин хяналтын станц /CN01162391/

TMDFS суурин хяналтын станц /TMDFS-M501/

FMS-2020 суурин хяналтын станц /RmcFX2dm02Mn/


4. Норматив бичиг баримт:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандарт


5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	М.Болдбат	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын ахлах инженер
2	М.Чагнаадорж	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:



Зураг 2. Радио давтамжийн 87.5 МГц-108.0 МГц-ийн зурвасын хэмжилт.



Зураг 3. FM радио нэвтрүүлэх станцуудын цацаргалтын параметруудын хэмжилт.

7. Хэмжилтийн дүн:

Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийдэг. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 34 хуулийн этгээдийн FM радиогийн нэвтрүүлэх станцуудад 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 28-ны өдрүүдэд суурин хяналтыг хийж гүйцэтгэлээ. Тус хяналтаар 6 FM радиогийн нэвтрүүлэх станцын давтамжийн хазайлтын максимум утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, эдгээрээс 1 FM радиогийн нэвтрүүлэх станцын хэрэглэх зурвасын өргөн стандарт хэмжээнээс хэтэрсэн, 1 FM радиогийн нэвтрүүлэх станц үйл ажиллагаагаа түр зогсоосон, 27 FM радиогийн нэвтрүүлэх станц хэвийн ажиллаж байгаа нь тогтоогдлоо.


7.1 Үйл ажиллагаагаа түр зогсоосон:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	22800029	98.5

7.2 Стандартын шаардлагыг хангасан:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг хангаж үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22800192	88.3
2	Жавзандамба хутагт төв ТББ	22800186	89.7
3	Улаанбаатар телевиз ХХК	22800178	90.5
4	Монгол комикс ХХК	22800159	91.1
5	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7
6	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
7	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
8	Шүхэр ТББ	22800117	95.1
9	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	95.7
10	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
11	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
12	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд	22800071	97.5
13	Радиоком Монгол ХХК	22800025	98.1
14	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
15	Билэгт дөлгөөн ХХК	22800060	99.7
16	Рф ХХК	22800005	100.1
17	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	100.9
18	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
19	Бадруун ХХК	22800006	102.5
20	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	103.1
21	Ви Өү Эм ХХК	22800052	104.0
22	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
23	Чугу ХХК	22800037	105.5
24	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	106.0
25	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6
26	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0
27	Билэг санаа ХХК	22800018	107.5




Зураг 4. Зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт нь стандартын шаардлагыг хангасан FM радио нэвтрүүлэх станцууд.

7.3 Стандартын шаардлагыг хангаагүй:

- MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй буюу давтамжийн хазайлт /Deviation/-ын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн хуулийн этгээдийн мэдээлэл:


№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	СКОД ХХК	22800167	88.8
2	Сета тех ХХК	22800193	89.3
3	Нью медиа ХХК	22800026	99.3
4	НС Холбоо ХХК	22800040	100.5
5	Агрегатор ХХК	22800022	101.7
6	Медиа холдинг ХХК	22800009	103.6



Зураг 5. Давтамжийн хазайлтын максимум утга нь стандарт хэмжээнээс хэтэрсэн FM радио нэвтрүүлэх станцууд.

- MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй буюу хэрэглэх зурвасын өргөн /Bandwidth/ нь 300 кГц-ээс хэтэрсэн хуулийн этгээдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	НС Холбоо ХХК	22800040	100.5



Зураг 6. Хэрэглэх зурвасын өргөн нь стандарт хэмжээнээс хэтэрсэн FM радио нэвтрүүлэх станц.

8. Дүгнэлт:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хэт богино долгионы FM радио нэвтрүүлэх станцуудын 79.4 % нь MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.

Дээрх стандартын шаардлагыг хангахгүй байгаа шалтгаан нь тухайн радиогийн нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдийн тохиргооноос хамаарч байна. Иймд радиогийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы цацаргалтын параметруудыг стандарт хэмжээнд байлгах, сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд буюу антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабел (фидер кабел, аудио кабел)-д тогтмол техникийн хяналт, үзлэг, үйлчилгээ хийж байх, студийн дууны холигч пультны түвшинг тогтмол хянаж, стандарт хэмжээнд тохируулж байхыг зөвлөж байна.